

ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дорноговь аймгийн Мал эмнэлгийн газрын 2019 оны
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДГА-2020/164/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Дорноговь аймаг

2020 он

Тэргүүлэх аудитор: Ч.Ариунаа

Утас: .70522734 Цахим хаяг: ariunaa.ch@audit.gov.mn

Аудитын менежерийн үүргийг

түр орлон гүйцэтгэгч: Э.Энхцэцэг

Утас: 70523020 Цахим хаяг: enkhtsetseg.e@audit.gov.mn

Аудитор: Ц.Ганцэцэг

Утас: 99060263 Цахим хаяг: shilenbalanceaudit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Агуулга

1	Аудитын гэрчилгээ.....	3
2	Аудитын тайлан	4
	2.1. Оршил.....	4
	2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
	2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
	2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	5
	2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
	2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	6
	2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	6
	2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	7
	2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	8
	2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	9
	2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	10
	2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт.....	12
	2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	12
3	Менежментийн захидал	13
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан	14
	4.1. Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан /төгрөгөөр/	14
	4.2. Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан /төгрөгөөр/	165
	4.1 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан /төгрөгөөр/.....	17
	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан /төгрөгөөр/.....	19
	4.5. Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /төгрөгөөр/.....	20

1 Аудитын гэрчилгээ


**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,
3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр,
Утас: (705) 2-27-34
Вэб сайт: dornogovi@audit.gov.mn

ДОРНОГОВЬ АЙМГИЙН МАЛ
ЭМНЭЛГИЙН ГАЗРЫН ДАРГА
Б.БАЯРМАНДАХ ТАНАА

2020.02.28 № 1-6/139
танай _____ -ны № _____ -т

Аудитын гэрчилгээ

Монгол Улсын Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Мал эмнэлгийн газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Дорноговь аймгийн Мал эмнэлгийн газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Дорноговь аймгийн Мал эмнэлгийн газрын 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагын хэмжээнд мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллага үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.АРИУНАА

2 Аудитын тайлан

2.1. Оршил

Дорноговь аймгийн Мал эмнэлгийн газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Баярмандах танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Мал эмнэлгийн газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймгийн Мал эмнэлгийн газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 01 сарын 25-ны өдрөөс 2020 оны 02 сарын 28-ны өдрийн хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 сарын 29-ний өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Шилэн баланс Аудит ХХК-ний аудитор Ц.Ганцэцэг хариуцаж хэрэгжүүлэв.

Дорноговь аймгийн Мал эмнэлгийн газар 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорноговь аймаг дахь төрийн аудитын газар 2020 оны 01 сарын 25-ны өдрийн 34 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн боловч тайлан алдаатай гарсан байна. 2020 оны 01 сарын 25-ний өдрөөс хойш 2020 оны 02 сарын 07, 17, 19, 25, 28-ны өдрүүдэд 5 удаа өөрчилж өгсөн.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Дорноговь аймгийн Мал эмнэлгийн газрын талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Дорноговь аймгийн мал эмнэлгийн газрын эрхэм зорилго нь мал өвчний өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх, мал амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний эрүүл аюулгүй байдлыг баталгаажуулах, нийтийн эрүүл мэндийг хамгаалах замаар мал эмнэлгийн салбарыг оновчтой нэгдсэн бодлогоор хангагч, худалдааны чөлөөт байдлыг дэмжихэд оршино гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилгоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Үүсгэн байгуулагчийн 2018 оны 09 сарын 12-ны өдрийн 267 дугаар тушаалаар үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Мал эмнэлгийн үйл ажиллагаа

Байгууллагын төсвийн захирагч нь Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль бусад холбогдох эрх зүйн актуудын хүрээнд үйл ажиллагаагаа явуулж байна.

Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль, тогтоомж түүнд нийцүүлэн гаргасан журам зааварт өөрчлөлт ороогүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан.

Тус Дорноговь аймгийн Мал эмнэлгийн газрын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Дорноговь аймгийн Мал эмнэлгийн газар нь нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа "Dynamic" программ хангамж ашигладаг байна.

Дорноговь аймгийн Мал эмнэлгийн газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн, гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Дорноговь аймгийн Мал эмнэлгийн газрын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд 42 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож эрсдэлийн түвшинг бага гэж үнэлэн 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 2,050,676.1 болох мянган төгрөгөөс 41,013.5 материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Дорноговь аймгийн Мал эмнэлгийн газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос

2,066,454,116.8 мянган төгрөгөөр буюу 100.0 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан. мөнгөн хөрөнгө, авлага, урьдчилж гарсан зардал, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага			
Урьдчилгаа			
Бараа материал		1,464,151.7	1,464,151.7
Үндсэн хөрөнгө		602,302,381.91	602,302,381.91
Нийт хөрөнгө		2,066,454,116.80	2,066,454,116.80
Өр төлбөр			
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/		2,066,454,116.80	2,066,454,116.80
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн		2,066,454,116.80	2,066,454,116.80

Тус байгууллага нь шинээр үүсгэн байгуулагдсан тул авлага үүсээгүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 1,464,151.7 мянган төгрөг байгаа нь тус газар нь 2019 оны 01 сарын 01-ний өдрөөс эхлэн аймгийн ХХААГазраас салж үйл ажиллагаагаа явуулж эхэлснээр тусгай материалын үлдэгдэл 543.4 мянган төгрөгийн, эм боох материалын үлдэгдэл 1,440,334.7 мянган төгрөгийн, бичиг хэргийн материалын үлдэгдэл 1,815.4 мянган төгрөгийн, аж ахуйн материалын үлдэгдэл 9,901.9 мянган төгрөгийн, түлш шатах тослох материалын үлдэгдэл 1,615.3 мянган төгрөгийн, бусад хангамжийн материалын үлдэгдэл 6,279.0 мянган төгрөгийн үлдэгдлийг шилжүүлэн авснаас шалтгаалжээ.

Тайлант онд шинээр үйл ажиллагаа эхлэн явуулж байгаа тул ашиглалтгүй бараа материалын үлдэгдэл байхгүй байна.

Тайлант онд 75,138.3 мянган төгрөгийн материал худалдан авсан, 1,711,147.5 мянган төгрөгийн /эм боох/ 543.4 /тусгай зориулалттай материал/ 5,420.0 /бусад хангамжийн материал/ мянган төгрөгийг шилжүүлэн авсан, 182,662.4 мянган төгрөгийг бүтцийн өөрчлөлтөөр /ХХААГ-аас/ шилжүүлэн авч зарцуулж, дээрх 1,464,151.7 мянган төгрөгийн үлдэгдлийг тайлагнасан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 911,907.6 мянган төгрөг болсон нь тайлант онд бүтцийн өөрчлөлтөөр буюу аймгийн ХХААГазраас 757,316.8 мянган төгрөгийн, хандиваар 30,500.0 мянган төгрөгийн, шилжүүлэн авсан 91,348.9 мянган төгрөгийн, худалдан авсан нийт 32,741.8 мянган төгрөгийн өсөлтөөс шалтгаалжээ.

Хандиваар болон үнэ төлбөргүй хүлээн авсан 879,165.8 мянган төгрөгийн хөрөнгө байна.

Биет бус хөрөнгийн 97,248.0 мянган төгрөг нь Хүнс хөдөө аж ахуйн газраас авсан газар, 1,180.0 мянган төгрөг нь худалдан авсан санхүүгийн программ хангамж байна.

Тайлант онд өр төлбөр үүсээгүй.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2,066,454,116.8 мянган төгрөг болжээ

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуульд зааснаар Дорноговь аймгийн Мал эмнэлгийн газар нь тайлант онд 2,000.0 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 1,245.4 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 62.3 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 2. Төвлөрүүлэх орлого

/мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Лабораторийн шинжилгээний орлого	2,000.0	1,008.0	992.0	50.4
Нийт дүн	2,000.0	1,008.0	992.0	50.4

Үндсэн үйл ажиллагааны орлого 754.6 мянган төгрөгөөр тасарсан нь лабораторийн тусгай зөвшөөрлийн хугацаа 2019 оны 10 сард дуусч үйл ажиллагаа явуулаагүйгээс шалтгаалсан байна.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрт зориулан .589,491.3 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 589,491.3 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 587,491.3 мянган төгрөгийг улсын төсвөөс, 2,000.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Урсгал зардлын гүйцэтгэлийг төлөвлөлттэй зэрэгцүүлсэн судалгаа хийхэд:

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	89,188.4	89,188.4	-	100.0
НДШ-ийн зардал	11,148.5	11,148.5	-	100.0
Гэрэл, цахилгаан	2,050.8	1,949.8	101.0	95.1
Түлш, халаалт	10,451.3	10,451.3	-	100.0

Дорноговь аймгийн Мал эмнэлгийн газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Цэвэр, бохир ус	854.5	761.0	93.5	89.1
Бичиг хэрэг	8,984.6	8,983.2	1.4	100.0
Тээвэр, шатахуун	16,925.9	16,925.9	-	100.0
Шуудан, холбоо, интернетийн төлбөр	3,518.4	3,507.4	11.0	99.7
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	480.0	160.0	320.0	33.3
БҮТЭЭ	513.6	496.8	16.8	96.7
Эм	80,554.2	56,065.0	24,489.2	69.6
Нормын хувцас зөөлөн эдлэл	1,232.8	1,192.0	40.8	96.7
Багаж хэрэгсэл	16,243.0	16,086.2	156.8	99.0
Урсгал засвар	30,543.8	29,336.0	1,207.8	96.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр	304,081.5	278,967.0	25,114.5	91.7
Ажил олгогчоос олгох нэг удаагийн тэтгэмж	5,000.0	3,796.0	1,204.0	75.9
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	7,720.0	5,247.7	2,472.3	68.0
Нийт зардлын дүн	589,491.3	534,262.2	55,229.1	90.6

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 535,262.2 мянган төгрөг буюу 90.6 хувьтай байгаа нь эмийн зардлыг 24,489.2 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөрийг 25,114.5 мянган төгрөгөөр бусад урсгал зардлуудыг 1,4-2,472.3 мянган төгрөгөөр зардлыг нийт дүнгээр нь 55,229.1 мянган төгрөгөөр хэмнэсэнтэй холбоотой байна.

Нэмэлт төсөв: Засгийн газрын нөөц сангаас 125,419,0. мянган төгрөг, дээд шатны төсвийн захирагчаас 879,289.4 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 1,239.5 мянган төгрөг, нийт 1,005,947.9 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөрт 983,214.9 мянган төгрөг, нэг удаагийн тэтгэмж урамшуулалд 900.0 мянган төгрөг, нийт 984,114.9 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 21,833.0 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 3 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 1 эрсдэл тодорхойлж нийт 4 горим сорил хэрэгжүүлжээ.

Аудитаар нийт 33,836.6 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 1,490.2 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 76.9 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 32,269.5 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

Аудитаар дараах 33,836.6 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 1,490.2 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 76.9 мянган төгрөгийн зөрчилт албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

1. 11 ажилтны албан томилолтын нөхөн олговрыг цалингийн бүтцэд оруулан тооцож эрүүл мэнд, нийгмийн даатгалын шимтгэл, хувь хүний орлогын албан татвар суутган авсан 76.9 мянган төгрөгийн алдаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” заалт, УСНББОУС 18 стандартын 27 заалттай нийцэхгүй, үнэн зөв байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх

2. Анхан шатны баримтын бүрдэл дутуу шаардлага хангахгүй баримтаар 1490.2 мянган төгрөгийн шатахуун зарцуулсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4-т “Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх” заалт, УСНББОУС 12 стандартын 44.заалттай нийцэхгүй, үнэн зөв байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох

Аудитаар илэрсэн 32,269.5 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Хөрөнгө, бараа материалын дансны ангилал, бүртгэлийг нарийвчлан авч үзэх шаардлагатай.

Дорноговь аймгийн Мал эмнэлгийн газар нь Хүнс хөдөө аж ахуйн газраас 2019 оны 01 сараас эхлэн үйл ажиллагаагаа салгаж бие даасан байгууллага болсон боловч эхлэлтийн баланс гаргалгүй 2019 оны эхний хагас жилийн тайлан, жилийн эцсийн санхүүгийн тайлан гаргасныг дахин хянах хэрэгтэй

2.13. Шилэн дансны мэдээлэл

Дорноговь аймгийн Мал эмнэлгийн газар нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 30 мэдээллийг хугацаанд нь, 97 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Тайлант онд шинээр байгуулагдсан тул өмнөх онд санхүүгийн аудитаар ороогүй.

2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Дорноговь аймгийн Мал эмнэлгийн газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Дорноговь аймгийн Мал эмнэлгийн газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3 дахь заалтын дагуу үнэн зөв илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Дорноговь аймгийн Мал эмнэлгийн газрын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Аудитаар бараа материалын дансанд түүврийн горим хэрэгжүүлэхэд 31,455.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг бүртгэж тайлагнасан байна.
2. Эд хөрөнгийн зардлаас гарах 814.0 мянган төгрөгийн үнэ бүхий 2 ширхэг орны үнийг урсгал засварын зардлаас гарган зарцуулсан байна.

Менежментийн захидал

3.1. Балансын данстай холбоотой асуудал

3.1.1. Илрүүлэлт

Түүвэрлэлтээр бараа материалын дансанд 31,455.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө бүртгэж тайлагнасан байна.

Энэ нь ангилал, үнэн зөв байх, эрх ба үүрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 4.16 “Бараа материалыг ангилж бүртгэхдээ дансны нэгдсэн жагсаалт болон холбогдох УСНББҮУС-ыг мөрдөх заалтыг зөрчиж байна.

3.1.2. Эрсдэл

Хуулийн хэрэгжилт хангагдахгүй байх

3.1.3 Зөвлөмж

Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 4.16 “Бараа материалыг ангилж бүртгэхдээ дансны нэгдсэн жагсаалт болон холбогдох УСНББОУС-ыг мөрдөх заалтыг хэрэгжүүлж ажиллах

3.1.4. Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: Зөвлөмжтэй танилцсан хэрэгжүүлж ажиллана.

3.2. Батлагдсан төсөвтэй холбоотой

3.2.1 Илрүүлэлт

Эд хөрөнгийн зардлаас гарах 814.0 мянган төгрөгийн үнэ бүхий 2 ширхэг орны үнийг урсгал засварын зардлаас гаргаж зарцуулсан байна

Энэ нь үнэн зөв байх, эрх ба үүрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Сангийн сайдын 2015 оны 07 дугаар тушаалын 2-т “Шинэчилсэн ангиллыг төсвийн төлөвлөгөө бэлтгэх, төсвийн гүйцэтгэлд хяналт тавих, төсвийн гүйцэтгэлийн тайлан гаргахад ашиглаж байх” заалтыг зөрчиж байна.

3.2.2. Эрсдэл

Төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулах

3.2.3 Зөвлөмж

Төсвийн зарцуулалтын эдийн засгийн ангиллыг мөрдөж Сангийн сайдын 2015 оны 07 дугаар тушаалын 2-т “Шинэчилсэн ангиллыг төсвийн төлөвлөгөө бэлтгэх, төсвийн гүйцэтгэлд хяналт тавих, төсвийн гүйцэтгэлийн тайлан гаргахад ашиглаж байх” заалтыг хэрэгжүүлж ажиллах.

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлж, биелэлтийг Дорноговь аймаг дахь Төрийн аудитын байгууллагад 2020 оны 05 сарын 30-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1. Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	0.00	1,464,151,734.89
35	БАРАА МАТЕРИАЛ	0.00	1,464,151,734.89
351	Түүхий эд материал	0.00	1,440,878,157.09
35110	Тусгай зориулалттай материал	0.00	543,400.00
35130	Эм боох материал	0.00	1,440,334,757.09
354	Хангамжийн материал	0.00	23,273,577.80
35410	Бичиг хэргийн материал	0.00	1,815,370.00
35420	Аж ахуйн материал	0.00	9,901,899.80
35430	Сэлбэг хэрэгсэл	0.00	3,662,010.00
35440	Түлш, шатах тослох материал	0.00	1,615,300.00
35470	Бусад хангамжийн материал	0.00	6,278,998.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	0.00	602,302,381.91
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	0.00	602,302,381.91
392	Биет хөрөнгө	0.00	504,051,048.61
39201	Барилга, байгууламж, орон сууц	0.00	232,336,935.50
39202	Хуримтлагдсан элэгдэл	0.00	(18,244,028.96)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	0.00	88,948,772.52
39204	Хуримтлагдсан элэгдэл	0.00	(62,415,439.27)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	0.00	289,453,851.15
39206	Хуримтлагдсан элэгдэл	0.00	(67,171,747.13)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	0.00	39,815,084.20
39208	Хуримтлагдсан элэгдэл	0.00	(15,071,648.32)
39214	Бусад үндсэн хөрөнгө	0.00	162,925,003.51
39215	Хуримтлагдсан элэгдэл	0.00	(146,525,734.59)
393	Биет бус хөрөнгө	0.00	98,251,333.30
39301	Програм хангамж	0.00	1,180,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	0.00	(176,666.70)
39303	Бусад биет бус хөрөнгө	0.00	97,248,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	0.00	2,066,454,116.80
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	0.00	2,066,454,116.80
51	Засгийн газрын хувь оролцоо	0.00	2,066,454,116.80
512	Хуримтлагдсан үр дүн	0.00	1,993,429,539.89
51210	Өмнөх үеийн үр дүн	0.00	(73,024,576.91)
51220	Тайлант үеийн үр дүн	0.00	2,066,454,116.80
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	0.00	73,024,576.91
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	0.00	2,066,454,116.80

4.2. Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	0.00	4,109,843,498.43
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	0.00	2,516,404,258.43
120	Нийтлэг татварын бус орлого	0.00	2,516,404,258.43
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	0.00	1,005,898.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	1,005,898.00
120015	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө-ТӨҮГ		255,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого- Үндсэн хөрөнгө		615,369,896.75
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Материал		1,899,773,463.68
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	0.00	1,593,439,240.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	0.00	587,491,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	0.00	587,491,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	1,005,947,940.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	125,419,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	879,289,440.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	0.00	1,239,500.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	0.00	2,043,389,381.63
21	УРСГАЛ ЗАРДАЛ	0.00	2,043,389,381.63
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	0.00	1,961,173,619.50
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	0.00	89,188,399.96
210101	Үндсэн цалин	0.00	71,734,399.96
210102	Нэмэгдэл	0.00	13,674,000.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0.00	3,780,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	0.00	11,148,500.00
210201	Тэтгэврийн даатгал	0.00	7,581,000.00
210202	Тэтгэмжийн даатгал	0.00	891,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	0.00	713,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	0.00	178,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	0.00	1,783,700.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	0.00	13,162,170.00
210301	Гэрэл, цахилгаан	0.00	1,949,830.00
210302	Түлш, халаалт	0.00	10,451,300.00
210303	Цэвэр, бохир ус	0.00	761,040.00
2104	Хангамж, бараа материалын зардал	0.00	36,743,902.50
210401	Бичиг хэрэг	0.00	5,961,900.00
210402	Тээвэр, шатахуун	0.00	22,227,650.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	0.00	2,948,951.50

Дорноговь аймгийн Мал эмнэлгийн газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	0.00	160,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	0.00	3,343,949.00
210408	Бараа материал акталсны зардал	0.00	2,101,452.00
2105	Нормативт зардал	0.00	528,553,514.49
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	0.00	527,593,514.49
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	0.00	960,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	0.00	16,946,200.00
210604	Урсгал засвар	0.00	16,946,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	0.00	1,206,980,502.71
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0.00	1,205,937,602.71
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	0.00	240,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	0.00	500,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	0.00	147,900.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	0.00	55,000.00
210807	Газрын төлбөр	0.00	100,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	58,450,429.84
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	12,641,115.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	0.00	45,809,314.84
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.00	82,215,762.13
2132	Бусад урсгал шилжүүлэг	0.00	6,147,691.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0.00	6,147,691.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.00	76,068,071.13
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	54,235,080.53
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг		21,832,990.60
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	0.00	2,066,454,116.80
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	0.00	2,066,454,116.80

4.3. Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан /төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	-	1,603,270,884.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	1,794,944.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	1,794,944.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	1,005,898.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	1,005,898.00
120009	Бусад орлого	-	789,046.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	-	1,601,475,940.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	-	587,491,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	587,491,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	1,013,984,640.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	125,419,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	879,289,440.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	9,276,200.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	-	1,570,529,084.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	1,570,529,084.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	1,488,313,321.87
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	89,188,399.96
210101	Үндсэн цалин	-	71,734,399.96
210102	Нэмэгдэл	-	13,674,000.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	3,780,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	11,148,500.00
210201	Тэтгэврийн даатгал	-	7,581,000.00
210202	Тэтгэмжийн даатгал	-	891,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	-	713,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	-	178,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	-	1,783,700.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	13,162,170.00
210301	Гэрэл, цахилгаан	-	1,949,830.00
210302	Түлш, халаалт	-	10,451,300.00
210303	Цэвэр, бохир ус	-	761,040.00
2104	Хангамж, бараа материалын зардал	-	30,073,257.50
210401	Бичиг хэрэг	-	8,983,170.00
210402	Тээвэр, шатахуун	-	16,925,900.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	3,507,351.50

Дорноговь аймгийн Мал эмнэлгийн газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	160,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	496,836.00
2105	Нормативт зардал	-	57,256,985.30
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	56,064,985.30
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	1,192,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	24,050,350.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	381,350.00
210604	Урсгал засвар	-	23,669,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	1,250,811,913.11
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	1,249,769,013.11
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	240,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	-	500,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	147,900.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	55,000.00
210807	Газрын төлбөр	-	100,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	12,621,746.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	12,621,746.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	82,215,762.13
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	6,147,691.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	6,147,691.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	76,068,071.13
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	54,235,080.53
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	-	21,832,990.60
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	=	<u>32,741,800.00</u>
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	32,741,800.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	32,741,800.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	32,741,800.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	32,741,800.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	=	<u>(32,741,800.00)</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

4.4.Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан /төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	(73,024,576.91)	(73,024,576.91)
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	73,024,576.91	-	73,024,576.91
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	2,066,454,116.80	2,066,454,116.80
D09	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	73,024,576.91	1,993,429,539.89	2,066,454,116.80

4.5. Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Дүнгээр	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	589,491,300.00	534,262,117.47	55,229,182.53	90.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	589,491,300.00	534,262,117.47	55,229,182.53	90.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	581,771,300.00	529,014,426.47	52,756,873.53	90.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	89,188,400.00	89,188,399.96	0.04	100.00
210101	Үндсэн цалин	71,734,400.00	71,734,399.96	0.04	100.0
210102	Нэмэгдэл	13,674,000.00	13,674,000.00	-	100.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,780,000.00	3,780,000.00	-	100.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	11,148,500.00	11,148,500.00	-	100.0
210201	Тэтгэврийн даатгал	7,581,000.00	7,581,000.00	-	100.0
210202	Тэтгэмжийн даатгал	891,900.00	891,900.00	-	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	713,500.00	713,500.00	-	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	178,400.00	178,400.00	-	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	1,783,700.00	1,783,700.00	-	100.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	13,356,600.00	13,162,170.00	194,430.00	98.5
210301	Гэрэл, цахилгаан	2,050,800.00	1,949,830.00	100,970.00	95.1
210302	Түлш, халаалт	10,451,300.00	10,451,300.00	-	100.0
210303	Цэвэр, бохир ус	854,500.00	761,040.00	93,460.00	89.1
2104	Хангамж, бараа материалын зардал	30,422,500.00	30,073,257.50	349,242.50	98.9
210401	Бичиг хэрэг	8,984,600.00	8,983,170.00	1,430.00	100.0
210402	Тээвэр, шатахуун	16,925,900.00	16,925,900.00	-	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,518,400.00	3,507,351.50	11,048.50	99.7
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	480,000.00	160,000.00	320,000.00	33.3
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	513,600.00	496,836.00	16,764.00	96.7
2105	Нормативт зардал	81,787,000.00	57,256,985.30	24,530,014.70	70.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	80,554,200.00	56,064,985.30	24,489,214.70	69.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,232,800.00	1,192,000.00	40,800.00	96.7
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	46,786,800.00	45,422,150.00	1,364,650.00	97.1
210601	Багаж, техник, хэрэгсэл	16,243,000.00	16,086,150.00	156,850.00	99.0
210604	Урсгал засвар	30,543,800.00	29,336,000.00	1,207,800.00	96.1

Дорноговь аймгийн Мал эмнэлгийн газрын 2019 оны санхүүгийн
тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	304,081,500.00	278,966,963.71	25,114,536.29	91.7
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	302,666,900.00	277,924,063.71	24,742,836.29	91.8
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	500,000.00	240,000.00	260,000.00	48.0
210803	Даатгалын үйлчилгээ	600,000.00	500,000.00	100,000.00	83.3
210804	Тээврийн хэрэгслийн татвар	159,600.00	147,900.00	11,700.00	92.7
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	55,000.00	55,000.00	-	100.0
210807	Газрын төлбөр	100,000.00	100,000.00	-	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,000,000.00	3,796,000.00	1,204,000.00	75.9
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,000,000.00	3,796,000.00	1,204,000.00	75.9
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7,720,000.00	5,247,691.00	2,472,309.00	68.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	7,720,000.00	5,247,691.00	2,472,309.00	68.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	7,720,000.00	5,247,691.00	2,472,309.00	68.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	587,491,300.00	533,256,219.47	54,235,080.53	90.8
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	587,491,300.00	533,256,219.47	54,235,080.53	90.8
122005	Орон нутгийн төсвөөс	587,491,300.00	533,256,219.47	54,235,080.53	90.8
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-	-
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	48.00	34.00	14.00	70.8
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	48.00	34.00	14.00	70.8
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	35.00	21.00	14.00	60.0
620003	Үйлчлэх ажилтан	12.00	12.00	-	100.0

Дорноговь аймгийн Мал эмнэлгийн газрын 2019 оны санхүүгийн
тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /НЭМЭЛТ ДАНС/ /төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	0.00	992,151,649.40
21	УРСГАЛ ЗАРДАЛ	0.00	992,151,649.40
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	0.00	991,251,649.40
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		
		0.00	983,214,949.40
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	983,214,949.40
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	8,036,700.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	8,036,700.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.00	900,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	0.00	900,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	900,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	0.00	1,013,984,640.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	1,013,984,640.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	125,419,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	879,289,440.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	0.00	9,276,200.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		